

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2015 ОНЫ
02 ДУГААР САРД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН
ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА**

2015 оны 03 дугаар

Баянхонгор

сарын 03-ны өдөр


Нэг. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол мэдээлэл

Тус цагдаагийн газар нь 2015 оны 02 дугаар сар

- Энэ хугацаанд нийт 667 гомдол, мэдээлэл хүлээн авсан нь урьд оны мөн үетэй харьцуулахад 91 нэгжээр буюу -12 хувиар буурсан.
- 200 буюу 30 хувийг гэмт хэргийн шинжтэй,
- 447 буюу 67 хувийг захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл
- Үлдэгдэл 18 гомдол, мэдээлэл шалгагдаж байна.

Нийт хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй 200 гомдол, мэдээллийн 84 буюу 42 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэж, 116 буюу 58 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлж шалгасан байна.

Хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 117 буюу 58,5 хувийг хуулийн анхны хугацаанд, 83 буюу 41,5 хувийг 5-19 хоногийн хугацаанд, захиргааны зөрчлийн шинжтэй 447 гомдол, мэдээллийн 446 буюу 100 хувийг 14 хоногт тус тус шийдвэрлэсэн.



Захиргааны зөрчлийн 447 гомдол, мэдээллийн:

- 348 буюу 77,8 хувийг торгуулийн хуудсаар,
- 67 буюу 15 хувийг шийтгэврээр торгох,
- 19 буюу 4,2 хувийг баривчлах,

- 13 буюу 3 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус ногдуулсан.


Хоёр. Гэмт хэргийн байдал

1. Аймгийн хэмжээнд 2015 оны 02 дугаар сард 84 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 14 нэгжээр буюу 20 хувиар өссөн байна.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 46 буюу 54.7 хувь нь Баянхонгор суманд, 38 буюу 45.2 хувь нь бусад суманд гарсан.

Энэ онд бүртгэгдсэн 88 гэмт хэргийн 38 хэргийг хэрэг бүртгэгч, 50 хэргийг мөрдөн байцаагч шалгаж, ЭБШХ-ийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр 4 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт шилжүүлсэн.

Баянхонгор сумын багуудад гарсан гэмт хэрэг




Гэмт хэргийн гаралтыг сумдаар нь харьцуулсан байдал



2. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал:

- Хөнгөн ангилалын гэмт хэрэг 39 бүртгэгдэж 11 нэгжээр буюу 39 хувиар өссөн,
- Хүндэвтэр ангилалын гэмт хэрэг 38 бүртгэгдэж, 2 нэгжээр буюу 5,5 хувиар өссөн,
- Хүнд ангилалын гэмт хэрэг 4 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй ижил түвшинд,



- Онц хүнд ангилалын гэмт хэрэг 3 бүртгэгдэж 1 нэгжээр буюу 50 хувь өссөн.

3. Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэрэг:

10 хэрэг бүртгэгдэснээс 3 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон. Одоо бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй бусдын эд хөрөнгийг хулгайлах 7 гэмт хэрэг байна. Үүнээс 2 нь мал хулгайлах гэмт хэрэг байна.

4. Гэмт хэргийн илрүүлэлт:

- Нийт хэргийн илрүүлэлт 30 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 20 пунктээр буурсан байна.
- Хөнгөн гэмт хэргийн илрүүлэлт 0 хувьтай, 66,7 пунктээр буурсан,
- Хүндэвтэр гэмт хэргийн илрүүлэлт 60 хувьтай, 26,7 пунктээр өссөн,
- Хүнд, онц хүнд эзэнгүй хэрэг бүртгэгдээгүй.



5. Бүртгэгдсэн гэмт хэргийг өнгөөр нь авч үзвэл:

| Нийт хэрэг | 2014 оны 02-р сар | 2015 оны 02-р сар | Харьцуулалт | |
|---|----------------------|----------------------|-------------|--------|
| | | | Тоо | Хувь |
| Хүн амь | 2 | 1 | -1 | -50% |
| Золгүй учрал | 1 | 1 | | |
| ББМБГУ | 20 | 35 | 15 | 75% |
| Хүчиндэх | 4 | 2 | -2 | -50% |
| Бусдын эд хөрөнгө хулгайлах /үүнээс/ | 22 | 24 | 2 | 9% |
| Малын хулгай | 11 | 12 | 1 | 9% |
| Иргэдийн өмчийн хулгай | 11 | 9 | -2 | -18% |
| Булаалт | 1 | 0 | -1 | -100% |
| Дээрэм | 1 | 0 | -1 | -100% |
| Залилан | 0 | 0 | | |
| Танхай | 3 | 2 | -1 | -33,3% |
| ТХХАБАЖЭГэмт хэрэг | 7 | 8 | 1 | 14,2% |
| Бусад | 9 | 11 | 2 | 22,2% |

6. Бүлэглэн үйлдсэн хэрэг 17 бүртгэгдэж 6 нэгжээр буюу 54 хувиар өссөн,

- эмэгтэй хүн оролцсон хэрэг 10 бүртгэгдэж 4 нэгжээр буюу 66,6 хувиар өссөн,
- хүүхэд оролцсон хэрэг 5 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй ижил түвшинд,

- согтуугаар үйлдэгдсэн хэрэг 29 бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үетэй ижил түвшинд,
- гудамж талбайд 16 хэрэг бүртгэгдэж 10 нэгжээр буюу 1,6 дахин өссөн,
- гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 21 бүртгэгдэж 1 нэгжээр буюу -4,5 хувиар буурсан байна.




7. Гэмт хэрэгт 93 хүн холбогдон шалгагдсан:

- 14-17 насны 5, - төрийн албан хаагч – 10,
- 18-с дээш насны 88, - оюутан сурагч – 6,
- Эмэгтэй 10, - ажилгүй – 26,
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч – 10, -урьд ял шийтгэгдсэн–1 бүртгэгдсэн.
- Малчин -41

8. Гэмт хэргийн улмаас 81 иргэн хохирсон: 4 хүн нас барж, 45 хүн гэмтсэн байна.

- 81,9 сая төгрөгийн хохирол учирснаас 37,7 сая төгрөгийг төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 46 хувьтай байна.

**Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, битүүмжилсэн хөрөнгө,
нөхөн төлүүлэлт /сая төгрөг/**



Гурав. Захиргааны зөрчлийн шийдвэрлэлт

Аймгийн хэмжээнд 2015 оны 02 дугаар сард 2016 захиргааны зөрчил бүртгэгдсэн нь: өнгөрсөн оны мөн үеэс 216 нэгжээр буюу 12 хувиар өссөн.

- 72 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 13 нэгжээр буюу -15,2 хувиар буурсан,
- 122 хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 21 нэгжээр буюу 20,8 хувиар өссөн,
- 1508 зөрчлийг торгуулийн хуудсаар 5813,0 мянган төгрөгөөр,
- 313 зөрчлийг шийтгэврээр 9879,0 мянган төгрөгөөр торгосон.
- 475 хүн саатуулж, 1,879,9 мянган төгрөгийн хураамж төлүүлж ажилласан.

ДҮГНЭЛТ

2015 оны 02 дугаар сард аймгийн хэмжээнд нийт 84 хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 14 нэгжээр буюу 20 хувиар өссөн. Хэргийн илрүүлэлт 30 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 20 пунктээр буурсан. Хэргийн гаралт 6 суманд буурч, 9 суманд өсөж 4 суманд ижил түвшинд байна. Хүнийг санаатай алах гэмт хэрэг 1 нэгжээр буюу 100 хувь, хүчин 2 нэгжээр буюу 50 хувь, иргэдийн өмчийн хулгай 2 нэгжээр буюу 18 хувь, булаалт, дээрэм тус тус 1 нэгжээр буюу 100 хувь, танхай 1 нэгжээр буюу 33,3 хувиар тус тус буурсан нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө гарч байна. Залилангийн гэмт хэрэг бүртгэгдээгүй байгаа нь урьд оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд байна.

Харин бусдын бие мах бодид гэмтэл учруулах 15 нэгжээр буюу 75 хувь, өмчийн хулгай 2 нэгжээр буюу 9 хувь, малын хулгай 1 нэгжээр буюу 9 хувь, хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэрэг 1 нэгжээр буюу 14,2 хувь, бусад гэмт хэрэг 2 нэгжээр буюу 22,2 хувиар тус тус өссөн байна. Насанд хүрээгүй

хүнээс үйлдсэн гэмт хэрэг 5 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй ижил түвшинд байна.

Нийт бүртгэгдсэн 84 гэмт хэргийн 18 буюу 21,4 хувь нь “Баасан” гарагт, 16 буюу 19 хувь нь “Бямба” гарагт тус тус үйлдэгдсэн, 25 буюу 30 хувь нь 19-22 цагт, 23 буюу 27,4 хувь нь тус тус 14-19, 22-06 цагуудад тус тус үйлдэгдсэн.

Гэр орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг 1 нэгжээр буюу 4,5 хувиар буурч, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 29 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй ижил түвшинд, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 10 нэгжээр буюу 1,6 дахин, бүлэглэн үйлдэгдсэн гэмт хэрэг 6 нэгжээр буюу 54 хувиар тус тус өссөн.

Илрүүлсэн зөрчил 216 нэгжээр буюу 12 хувиар өссөн.

САНАЛ

Орон нутгийн түвшинд:

-Төрийн албан хаагч, байгууллага аж ахуйн нэгжийн ажилчид гэмт хэрэг, зөрчилд холбогдож байгааг таслан зогсоохын тулд байгууллагын ажлыг дүгнэхдээ тухайн байгууллага хамт олноос гэмт хэрэг, зөрчилд холбогдсон байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээ зохиосон байдлыг харгалзах заалт оруулах

-Тодорхой төрлийн гэмт хэрэг цаашид өсөх хандлагатай байгааг ба зам тээврийн хэрэг, осол урьд оны мөн үеэс өссөн байна. Цагдаагийн байгууллагын зүгээс арга хэмжээ авч ажиллаж байгаа боловч энэ төрлийн гэмт хэрэг буурахгүй байна. Иймд “Сургуулийн цагдаа” эргүүлийг тогтмол идэвхтэй ажиллуулах.

-Гудамж талбай, гэр хорооллын гэрэлтүүлгийг сайжруулах, шөнийн цагаар байнга гэрэлтүүлэгтэй байлгах.

-Баянхонгор суманд байрлах хяналтын камерын тоог нэмэгдүүлж, шаардлагатай зарим газруудыг хяналтанд авах, шөнийн цагаар камерийн орчны гэрэлтүүлгийг сайжруулах арга хэмжээ авах

Цагдаагийн байгууллагын түвшинд:

-Хяналтын камерын ашиглалтыг сайжруулж түүгээр илрүүлсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажиллах.

-Малын хулгайн гэмт хэргийг бууруулах чиглэлээр аймгийн ИТХурал, ГХУСАЗЗөвлөл, бусад холбогдох албадтай төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллахад аймаг, сумдын удирдлагаас бусад газар хэлтэс, албыг татан оролцуулах зохицуулалтын арга хэмжээ авах.

-Насанд хүрээгүй хүнээс үйлдсэн гэмт хэрэг, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийг бууруулах, шалтгаан нөхцөлийг тогтоож арилгах, урьдчилан

сэргийлж, таслан зогсоох зорилгоор хэсэгчилсэн болон нэгдсэн арга хэмжээг зохион явуулах, уг арга хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг татан оролцуулах

-Хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч нар хариуцсан баг, сумын засаг дарга нартай хамтран тухайн нутаг дэвсгэрт дээрх төрлийн гэмт хэргийг бууруулах чиглэлээр арга хэмжээ зохиож, олон нийтийг татан оролцуулах.

-Гудамж талбай, олон нийтийн газар үйлдэгдсэн зөрчлийг илрүүлж, гэмт хэргийг бууруулах зорилгоор өдөр, орой, шөнийн хэв журмын эргүүл, хөдөлгөөнт эргүүлийн чиглэл, маршрут, хүн, хүчийг эрүү, хэв журмын нөхцөл байдалтай уялдуулан зохион байгуулж, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах.

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗАР**